



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн
2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2019/2/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор
2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 88089024 Цахим хаяг: tsetsegmaadam@audit.gov.mn

Аудитор: П.Амаржаргал

Утас: 88106992 Цахим хаяг: amar_802002@yahoo.com

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11	Шилэн дансны мэдээлэл	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	12
3.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	12
3.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	12
3.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	13
3.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	13
3.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	14

1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНХОНГОР АЙМГИЙН ХӨДӨЛМӨР Г
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ТӨСВИЙН ЗАХИРАГЧ
Д.АМАРСАНАА ТАНАА

2019.02.25 № 2/58

танай _____-ны № _____-т

Г

Г

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа

D:\Amaraa\amaraa\2019\hodolmor erhleltiig demjih san\Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан Аудитын гэрчилгээ ме-хянуулсан.docx

2519098

нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн дарга Д.Амарсанаа-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 08-наас 2019 оны 02 дугаар сарын 11-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 12-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор П.Амаржаргал хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 56 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлж, тэдгээрийн хамрах хүрээ, санхүүжүүлэлтийг нэмэгдүүлж сангийн үйл ажиллагааг өргөжүүлэх” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг санхүүжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санг өргөжүүлэх

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 41 буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Ахрoler" санхүүгийн программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "Дунд" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 3 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 3 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзсэнтэй холбоотой юм.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 572,3 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 5,7 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын төвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын төвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 3 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд алдаа, зөрчилтөйд залруулах асуудал гараагүй болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	60.6	
3	Албан шаардлага өгсөн	1	54.4	
	Дүн	2	115.0	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1 Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Улсын төсвөөс 1094,4 сая төгрөгийн санхүүжилт авахаас 1053,5 сая төгрөгийн санхүүжилт авч, зарцуулан, хөтөлбөрүүдийн батлагдсан төсвийг хэтрүүлээгүй байна. Төсвийн зарцуулалтыг анхан шатны баримтаас хөөн шалгахад тохирч байгаа ба 1323,7 сая төгрөгийн авлагыг хөтөлбөр тус бүрээр анхан шатны баримтаас түүвэрлэн тулгахад зөрүүгүй тохирсон. Харин Орон нутгийн онцлогтой зорилтот төслийн санхүүжилтийн мөнгийг төсөл, хөтөлбөрийн тэргүүлэх чиглэлтэй нийцээгүй болон шалгуур үзүүлэлтийг хангаагүй 4 төсөлд 54,4 сая төгрөгийг олгосон зөрчил илрэв.

Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2018 оны 07-р сарын 23-ны өдрийн А/204 дугаар тушаалын нэг, хоёрдугаар хавсралтын холбогдох заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн:

Хавсралтад заасан 4 иргэний зээлийн ашиглалтад дотоод хяналт шалгалт хийж зорилтод төслийн тэргүүлэх чиглэл, тавигдах ерөнхий шаардлага, шалгуур үзүүлэлтийн шаардлагад нийцүүлэх.

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Байхгүй

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 1094,3 сая төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 1094,3 сая төгрөг буюу 94,8 хувьтай байгаа нь 2018 онд 1037,9 сая төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулан 261,5 сая төгрөг төвлөрүүлэн шилжүүлсэн байна.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно. Шилэн дансны цахим мэдээллийн санд төсөв гүйцэтгэлтэй холбоотой 3-н төрлийн 36 мэдээ, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авахтай холбоотой 38, бусад төрлийн 60-н мэдээ тус бүрийг хуулийн хугацаандаа бүрэн оруулсан байна. Аудитын тайлан дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, байгууллагын батлагдсан төсөв /бүтэн жилээр/ оруулах мэдээллүүдийг хугацаандаа мэдээлээгүй байна.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3 зөвлөмжийг хэрэгжүүлэн, холбогдох хууль тогтоомжийн заалтыг мөрдөн ажилласан байна.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Төсөл хөтөлбөрт олгосон санхүүжилтийг зориулалтын дагуу санхүүжүүлсэн эсэхийг анхан шатны баримттай тулган шалгахад орон нутгийн онцлогтой зорилтот төслийн мөнгийг тэргүүлэх чиглэл, шалгуур үзүүлэлтийг хангаагүй төсөлд олгосон зөрчил илэрлээ

Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2018 оны 07-р сарын 23-ны өдрийн А/204 дугаар тушаалын нэг, хоёрдугаар хавсралтын холбогдох заалтыг тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Батлагдсан төсвийг үр ашигтай зарцуулаагүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төсөл хөтөлбөрийг батлагдсан журам, чиглэлийг баримталж сонгон шалгаруулж байх, 2018 онд шалгаруулж, оны эцсээр санхүүжүүлсэн /албан шаардлага өгөгдсөнөөс бусад/ төслүүдийн үйл ажиллагааг 2019.04.01-ны дотор эхлүүлж, хэрэгжилтийн явцад хяналт хийж тайланг 2019.05.15-ны дотор ирүүлэх

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 05 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

4.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	759515229.00	1343512664.00
33	АВЛАГА	759515229.00	1343512664.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	0.00	19771150.00
335	Бусад авлага	759515229.00	1323741514.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	759515229.00	1323741514.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	759515229.00	1343512664.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	759515229.00	1343512664.00
51	Засгийн газрын хувь оролцоо	759515229.00	1343512664.00
512	Хуримтлагдсан үр дүн	759515229.00	1343512664.00
51210	Өмнөх үеийн үр дүн	264354972.00	759515229.00
51220	Тайлант үеийн үр дүн	495160257.00	583997435.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	759515229.00	1343512664.00

4.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1048627400.00	1156356000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1080000.00	2856000.00
120	Нийтлэг татварын бус орлого	1080000.00	2856000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1080000.00	2856000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1080000.00	2856000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1047547400.00	1153500000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1047547400.00	1153500000.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	957547400.00	1053500000.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	90000000.00	100000000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	553467143.00	572358565.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	553467143.00	572358565.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	553467143.00	572358565.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	410973990.00	330974565.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	410973990.00	330974565.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	142493153.00	241384000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	142493153.00	241384000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	495160257.00	583997435.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	495160257.00	583997435.00

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1189980343.00	1399129715.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	142432943.00	245629715.00
120	Нийтлэг татварын бус орлого	142432943.00	245629715.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	142432943.00	245629715.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	141352943.00	242773715.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1080000.00	2856000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1047547400.00	1153500000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1047547400.00	1153500000.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	957547400.00	1053500000.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	90000000.00	100000000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1189980343.00	1399129715.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1189980343.00	1399129715.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1189980343.00	1399129715.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1047487190.00	1137974565.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1047487190.00	1137974565.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	142493153.00	261155150.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	142493153.00	261155150.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	759,515,229.00	0.00	759,515,229.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	759,515,229.00	0.00	759,515,229.00
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	759,515,229.00	0.00	759,515,229.00
2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	759,515,229.00	0.00	759,515,229.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	759,515,229.00	0.00	759,515,229.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	583,997,435.00	0.00	583,997,435.00
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	1,343,512,664.00	0.00	1,343,512,664.00

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9912862000.00	957547400.00	1094370200.00	1037974565.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9912862000.00	957547400.00	1094370200.00	1037974565.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	0.00	4000000.00	4000000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	0.00	4000000.00	4000000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	0.00	4000000.00	4000000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	991286200.00	957547400.00	1090370200.00	1033974565.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	991286200.00	957547400.00	1090370200.00	1033974565.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	991286200.0	957547400.0	1090370200.00	1033974565.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	991286200.00	957547400.00	1094370200.00	1037974565.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	991286200.00	957547400.00	1094370200.00	1037974565.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	991286200.0	957547400.0	1094370200.00	1037974565.00